



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/532

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан эрчим хүчний салбарт үр бүтээлтэй ажиллахын зэрэгцээ үйл ажиллагаандаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг хэрэгжүүлэх үйлсэд хамт олноо манлайлан идэвх санаачилгатай ажиллаж буй "Цахилгаан түгээх сүлжээ" хязгаарлагдмал хувцаат компанийн шугам сүлжээний мастер Т.Ширнэн, авлагын монтёр Б.Банзрагч, Цэцэг сумын байцаагч монтёр О.Батжаргал, архив бичиг хэргийн ажилтан Г.Оролмаа болон "Алтан замын жигүүр холбоо" төрийн бус байгууллагын гишүүн Г.Сонинтөр, Б.Нармандах, Ш.Жаргал, Д.Батмөнх, Ч.Цэвэгсүрэн нарыг аймгийн Засаг даргын "Хүндэт өргөмжлөл"-өөр шагнахад 270,000 төгрөг (хоёр зуун далан мянга)-ийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 270,000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

Zah A/532 Bo
8400 01 2704